БАТЛАВ
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ЖАМБАЛЦЭРЭН

"ЗҮҮН БҮСИЙН БАЙГАЛИЙН НӨХЦӨЛ НӨӨЦӨД ТУЛГУУРЛАН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, ХУДАЛДАА, БИРЖ, ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ЦОГЦОЛБОРЫН ТЭЗҮ" БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

№	Ажлын нэр төрөл	Ерөнхий шаардлага
1	Үндэслэл	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого: 4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно. 2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн байна. 8.1. Бүс нутгийн эдийн засгийн интеграцид дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлнэ. 4. Орон нутгийн тээвэр логистикийн нэгдсэн сүлжээг үе шаттайгаар байгуулж, олон улсын болон бүсийн тээвэр логистикийн сүлжээнд холбосон байна. - Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал: 3.1.18. Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр: 1.3.1.4. Бүс нутгийн онцлогт тохирсон мал үржүүлэг, үржлийн цөм сүрэг бий болгож, орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ. 1.4.2.1. Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг дэмжинэ.
2	Ажлын зорилго	Тухайн аймгийн хөгжлийн боломж, хөдөө аж ахуйн нөөц, онцлогт тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг байгуулж, орон нутагт иргэн, аж ахуйн нэгж,

		хоршоологчид үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах бизнесийн таатай орчинг бий болгох, ажлын байрыг нэмэгдүүлэх, улмаар иргэд болон орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах.
3	Хэрэгцээ шаардлага	Сүүлийн жилүүдэд хөдөө, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил нийслэлээс илт хоцорч, орон нутгаас нийслэл Улаанбаатар хотыг чиглэсэн урсгал бий болж, орон нутагт үйлдвэрлэл үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагаа явуулах боломж харьцангуй хязгаарлагдмал болсон нь хөгжлийн хэт ялгаатай, тэнцвэргүй байдлыг үүсгэсэн. Нөгөө талаараа орон нутагт тогтвортой бизнес эрхлэх малчдын орлогыг нэмэгдүүлэх боломж хомсдож хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин хангалттай түвшинд хүрч чадахгүй байна. Иймд бүс, орон нутгийн онцлогт тулгуурлан, бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн хөгжүүлэх, хөдөө орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг дэмжих, тухайн орон нутагтаа таатай амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэхтэй холбоотойгоор орон нутгийн эдийн засгийн нөөц чадавх, байгалийн нөөцийг бүрэн ашиглах, өртөг шингээсэн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолбор барих ТЭЗҮ боловсруулах шаардлага үүсээд байна.
4	Шийдвэрлэх үндсэн асуудал	Тухайн аймгийн орон нутгийн хөгжлийн төвд хөдөө аж ахуйн нөөцөд тулгуурлан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн цогцолборын жишиг загвар зураг боловсруулах ба дараах асуудлуудыг шийдвэрлэхээр тусгасан байна. Үүнд: А. Удирдлагын байр, оффис: • Төв удирдлага; • Оффис; • Шинжлэх ухаан, технологийн төв; Б. Үйлдвэрлэлийн хэсэг: • Мал аж ахуйн үйлдвэрлэл; • Боловсруулах үйлдвэр; • Лабораториуд; В. Худалдааны цогцолбор: • Худалдааны төв; • Үзвэр үйлчилгээ, амралт зугаалгын парк; Г. Суурьшлын бүс: • Орон сууцны барилгууд; • Төрийн болон нийгмийн үйлчилгээний байгууллагууд; Д. Логистикийн бүс: • Логистик; • Агуулахын байр талбай; Е. Инженерийн дэд бүтэц, гадна тохижилт: • Дулаан, цахилгаан, ус хангамжийн эх

		үүсвэр, шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, ариутгах татуурга; • Авто зогсоол, авто зам, дугуйн болон явган хүний зам, ногоон байгууламж, тоглоомын талбай зэрэг барилга байгууламж. 1. Орон нутгийн эдийн засгийн салбаруудын нөөц чадавх, байгаль, түүх, соёл, хөдөө аж ахуйн нөөц, давуу тал, онцлогт тулгуурласан эргэлтэд оруулах боломж бүхий эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хүчин чадлыг тодорхойлж, салбар болон үйл ажиллагааны төрөлжилт, хоршилт, дагналтын талаар санал боловсруулах, цаашдын хөгжлийн чиг хандлага, стратегийг боловсруулах; 2. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэх, олон улсын зах зээлд тухайн орон нутгаас бүтээгдэхүүн экспортлох боломжийг судлах; 3. Орон нутгийн хөгжлийн төвд хамаарах сумдад хэрэгжүүлэх бололцоо бүхий жишиг загвар зураг боловсруулах, төсөл арга хэмжээний холбогдох тооцоо судалгааг хийж, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөө, гүйцэтгэх үүрэг, оролцоог тодорхойлох, сумдын уялдаа холбоог хангах талаар санал боловсруулах; 4. Тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх; 5. Тухайн аймгийн орон нутгийн хөгжлийн төвд хөдөө аж ахуйн нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолбор байгуулах эдийн засгийн судалгаа, тооцооллыг хийх, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах, хувийн хэвшил, хоршоодын оролцоог тодорхойлох, нийгэм эдийн засгийн үр ашгийг тооцоолох; 6. Ижил төстэй цогцолборыг барьж байгуулсан улс орнуудын туршлага, төлөвлөлт, шийдлийг судлан цогцолборын төлөвлөлтөд тусгах, олон улсын стандартад нийцүүлэх; 7. Цогцолборын зам тээврийн сүлжээг улс, бүс, орон нутгийн авто замын сүлжээтэй уялдуулан төлөвлөх, инженерийн дэд бүтцийн хангамжийн төлөвлөлтийг эдийн засаг, техник технологийн оновчтой хувилбараар тооцон тусгах; 8. Цогцолборыг барьж байгуулах хамгийн оновчтой байршил, газрыг холбогдох эрх бүхий байгууллагуудын хүрээнд хийгдсэн судалгаа, тооцоо болон Засгийн газраас баримталж буй бодлого чиглэлтэй уялдуулах, барилга байгууламжийн хэмжээ, хүчин чадал, тэдгээрийн үзүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээний хэлбэр зэргийг тодорхойлох, орчин үеийн төлөвлөлтийн шийдлүүдтэй уялдуулан төлөвлөх. 9. Тухайн аймгийн орон нутгийн хөгжлийн төвд хөдөө аж ахуйн нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл, үйлчилгээ,

		бирж, тээвэр логистикийн цогцолборын жишиг загвар зургийн хувилбарыг гаргах бөгөөд дараах бүтэцтэй байна. Үүнд: • Үйлдвэрлэлийн төрөлжилтийг тодорхойлсны үндсэн дээр цогцолборын орон зайн төлөвлөлтийг оновчтой, эмх цэгцтэй байхаар зохион байгуулах, • Ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэн харилцан уялдаатай төлөвлөх, • Үйлдвэрлэлийн үр ашигтай эргэлтийг дэмжих зорилгыг хангахаар боловсруулна.
5	**Ажлын иж бүрдэл**	1. Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд: **Төслийн суурь судалгаа:** • Хууль эрх зүй, бодлогын баримт бичгийн судалгаа; • Макро, микро орчны шинжилгээ; • Орон нутгийн нийгэм, эдийн засаг, аж үйлдвэржилтийн судалгаа, • Хөдөө аж ахуйн нөөцийн судалгаа, • Газар ашиглалтын судалгаа; • Олон улсын тэргүүн туршлагын судалгаа; **Эрэлт, нийлүүлэлтийн шинжилгээ**: • Эрэлтийн шинжилгээ; • Нийлүүлэлтийн шинжилгээ; • Зөрүүгийн шинжилгээ; **Төслийн зорилго, зорилт болон цар хүрээг тодорхойлох**: • Төслийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага, үндэслэлийг тодорхойлох; • Зорилго, зорилт, хүрэх үр дүн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох; • Ажлын тоо, хэмжээ, хамрах хүрээг тодорхойлох; • Төслийн үр дүн, нөлөөлөх хүчин зүйлс, нийгэм эдийн засгийн үр нөлөөг тодорхойлох; **Төслийн бүтээгдэхүүн үйлчилгээ, техник технологийн шийдэл:** • Бүтээгдэхүүн үйлчилгээний тодорхойлолт; • Төслийг хэрэгжүүлэх техник, технологийн шийдэл; • Төслийг олон нийтэд хүргэх үйл ажиллагааны шийдлүүд; • Төслийн онцлогоос хамаарах бусад шийдэл, хувилбаруудыг гаргах; **Тухайн орон нутгийн хөгжлийн төвд үйлдвэрлэл хөгжүүлэх төлөвлөгөө:** • Одоо байгаа үйлдвэржилтийн түвшинд дүн шинжилгээ хийж үнэлэх, хөгжлийн түвшинг

		харьцуулсан үнэлгээнд үндэслэн тухайн орон нутагт хөгжүүлэх нөөц бололцоо; • Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөцийн үнэлгээ, хэтийн төлөвлөлт; • Жижиг, дунд үйлдвэрлэл, анхан, дунд шатны хоршоодыг хөгжүүлэх нөөц бололцоо, хэтийн төлөв; **Төслийн санхүү, хөрөнгө оруулалтын тооцоо:** • Төслийн анхны хөрөнгө оруулалтын тооцоо /хөрөнгө оруулалтын томсгосон тооцоо/; • Санхүүгийн тооцоолол; • Санхүүжилтийн эх үүсвэрийн боломжит хувилбарууд, • Санхүүжилтийн хуваарь; • Санхүү, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ, мэдрэмжийн шинжилгээ; • Нөхөн олговрын тооцоо; **Эрсдэлийн шинжилгээ:** • Төслийн эрсдэлийн шинжилгээ; • Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө; **Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний зөвлөмж:** • Төслийн бүтээн байгуулалтын хуваарь; • Удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн төлөвлөлт; • Төсөл хэрэгжүүлэх газрын газар ашиглалтын төлөвлөгөө; • Төслийг хэрэгжүүлэх инженерийн дэд бүтцийн хангамж; • Төслийг хэрэгжүүлэх ажлын үйл ажиллагааны төлөвлөгөө, үе шат; • Төслийг хэрэгжүүлэх бусад арга хэмжээ; **Жишиг загвар зураг:** • Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн жишиг загвар зургийн хувилбарууд /М1:1000/; • Байршлын схем /М1:100000/; • Цогцолборын барилга байгууламжийн жишиг загвар зургийн хувилбарууд /М1:200/; • Инженерийн дэд бүтцийн хангамж /М1:5000/; • Ерөнхий харагдах байдал /3D зураг/; • Төлөвлөлтийн онцлогийг харуулсан анимэйшн /2-3 минут/; **Төслийн үр дүнг тодорхойлох:** • Нэгдсэн санал, зөвлөмж; • Төслийг оновчтой хэрэгжүүлэх тогтолцоо, удирдлага, зохион байгуулалтын талаар тодорхой санал, дүгнэлт. 2. Тухайн аймгийн орон нутгийн хөгжлийн төвд хөдөө аж ахуйн нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборын

		жишиг загвар зураг: • Цогцолборын барилга байгууламж барих газрын оновчтой байршлыг тодорхойлох; • Цогцолборын барилга байгууламжийн жишиг загвар зургийн хувилбарууд; • Судалгаа, шинжилгээ, тооцооллын дүгнэлт, харьцангуй давуу, сул талуудын харьцуулалт, хөгжилд нөлөөлөх хүчин зүйлүүдийн тодорхойлолт, эдийн засгийн тооцоо; • Орон зайн төлөвлөлтийн үндсэн шийдэл; • Богино, дунд хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө.
6	**Онцгой нөхцөл**	• Төсөл хэрэгжих газар нутгийн хэмжээ, хамрах хүрээг судалгаагаар нарийвчлан тогтооно. • Дэвшилтэт техник технологийн шийдлийг тусгасан "хэмнэлттэй", ногоон төлөвлөлтийн үндсэн зарчмуудыг агуулсан, тухайн бүс нутгийн болон байгаль цаг уурын онцлогт зохицсон төлөвлөлтийн шийдэл бүхий хувилбаруудын жишиг загвар зургийг томсгосон өртгийн хамт боловсруулах.
7	**Ашиглах материал**	Хууль, дүрэм, журам: • Үндсэн хууль; • Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; • Барилгын тухай хууль; • Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль; • Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль; • Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль; • Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль; • Газрын тухай хууль; • Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль; • Байгаль орчныг хамгаалах тухай хууль; • Усны тухай хууль; • Ойн тухай хууль; • Соёлын өвийг хамгаалах тухай хууль; • Монгол Улсын Инновацын тухай хууль; • Эрчим хүчний тухай хууль; • Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль; • Хөрс хамгаалах тухай хууль; • Газрын хэвлийн тухай хууль; • "Харилцаа холбооны тухай хууль", Хот байгуулалтын баримт бичиг: Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого"; • “Хүнсний хангамж, аюулгүй байдал” УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоол;

		Бусад хууль тогтоомж, холбогдох стандарт, норм, норматив, дүрэм, заавар.
8	**Тайлан боловсруулах үе шат**	Эхлэлийн тайлан: • Арга зүйн хэлэлцүүлгийг зохион байгуулах, ажлын даалгаварт тусгагдсан бусад шаардлагатай хууль эрх зүйн баримт бичиг, суурь судалгаа хийхэд шаардлагатай өгөгдөл мэдээллийг цуглуулж боловсруулалт хийх; Дундын тайлан: • Суурь судалгаа, нөхцөл байдлын үнэлгээ; • Хөгжлийн хувилбар боловсруулах, үнэлгээ хийх; • Жишиг загвар зургийн үндсэн шийдэл; • Хэлэлцүүлэх, санал авах; Эцсийн тайлан: • Холбогдох байгууллагуудаас санал авах; • Хөгжлийн эцсийн хувилбар боловсруулах; • Жишиг загвар зургийн бүрдэл, тайлбар бичиг.
9	**Тендерт оролцогч багийн гишүүдэд тавигдах шаардлага**	Зөвлөх хуулийн этгээд нь бүс нутгийн төлөвлөлтийн арга зүй аргачлалтай, судалгаа боловсруулалтын ажлын туршлагатай, мэдээллийн бааз бүрдүүлэхэд шаардагдах мэдээллийн технологийн мэдлэг чадвартай, тоног төхөөрөмжтэй байх. Дараах мэргэжил ур чадвартай гишүүдээс бүрдэнэ. Үүнд: 1. Ахлах зөвлөх-1 (нэг) ▪ Хот ба бүс нутаг төлөвлөлт, архитектор, газар зохион байгуулалт, нийгэм эдийн засгийн газарзүйн мэргэжилтэй, доктор эрдмийн зэрэгтэй байх ▪ Мэргэшсэн архитектор байх ▪ Бүс нутгийн төлөвлөлтийн чиглэлээр эрдэм шинжилгээний ажил, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байсан болон бодлого боловсруулах төлөвлөлт хийх, ажлын 15 дээш жилийн туршлагатай байх ▪ Бие даан ажиллах зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай байх 2. Эдийн засгийн асуудал хариуцсан зөвлөх-1 (нэг) ▪ Эдийн засагч мэргэжилтэй доктор эрдмийн зэрэгтэй байх, ▪ Хот ба бүс нутаг төлөвлөлтийн зөвлөх эдийн засагч байх ▪ Макро болон бүс нутгийн эдийн засгийн чиглэлийн судалгаа, шинжилгээний ажлын болон бодлого боловсруулах, төлөвлөлт хийх ажлын 10 дээш жилийн туршлагатай байх ▪ Бие даан ажиллах зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай байх ▪ Тухайн чиглэлийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг судлах зохих шатны хэлний мэдлэгтэй байх

		3. Хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан зөвлөх-1 (нэг) ▪ Нийгмийн ухаан, улс төр судлалын мэргэжилтэй, доктор эрдмийн зэрэгтэй байх ▪ Монгол Улсын төрийн бодлого болон хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн чиглэлээр ажлын 10-аас дээш жилийн туршлагатай байх ▪ Үндэсний болон салбарын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах ажлын хэсэг, зөвлөх багт ажиллаж байсан туршлагатай байх ▪ Бие даан ажиллаж, зөвлөгөө өгөх, багаар ажиллах туршлагатай. 4. Уул уурхай, хүнд үйлдвэр асуудал хариуцсан зөвлөх -1 (нэг) ▪ Геологи уул уурхайн инженер, ашигт малтмалын эрэл хайгуул, баяжуулалтын технологи, металлурги, хими, химийн технологийн инженерийн мэргэжилтэй доктор эрдмийн зэрэгтэй байх ▪ Уул уурхай хүнд үйлдвэрийн судалгаа, шинжилгээ, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын болон бодлого боловсруулах, төлөвлөлт хийх 10-аас дээш жилийн ажлын туршлагатай байх ▪ Бие даан ажиллах зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай байх ▪ Тухайн чиглэлийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг судлах зохих шатны хэлний мэдлэгтэй байх 5. Хүнс, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан зөвлөх-1 (нэг) ▪ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын мэргэжилтэй доктор эрдмийн зэрэгтэй байх, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа шинжилгээний ажлын бодлого боловсруулах төлөвлөлт хийх ажлын 10-аас дээш жилийн туршлагатай байх ▪ Бие даан ажиллах зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай байх ▪ Тухайн чиглэлийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг судлах зохих шатны хэлний мэдлэгтэй байх 6. Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан зөвлөх-1 (нэг) ▪ Мал зүйч, малын эмч, агрономич, бэлчээр, тэжээлийн мэргэжилтэй, магистраас дээш эрдмийн зэрэгтэй байх ▪ Бэлчээрийн менежмент, нөхөн сэргээлт, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр ажлын 10-аас дээш жилийн туршлагатай байх

		▪ Судалгаа, шинжилгээний ажлын болон бодлого боловсруулах, төлөвлөлт хийх ажлын туршлагатай байх, ▪ Бие даан ажиллах зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай байх ▪ Тухайн чиглэлийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг судлах зохих шатны хэлний мэдлэгтэй байх 7. Байгаль орчин газарзүйн асуудал хариуцсан зөвлөх-1 (нэг) ▪ Байгаль орчин, экологич, цаг уур, хүрээлэн буй орчин газарзүйн мэргэжилтэй, доктор эрдмийн зэрэгтэй байх, ▪ Судалгаа, шинжилгээний ажлын болон бодлого боловсруулах, төлөвлөлт хийх ажлын 10 дээш жилийн туршлагатай байх, ▪ Бие даан ажиллах зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай байх ▪ Тухайн чиглэлийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг судлах зохих шатны хэлний мэдлэгтэй байх 8. Хот төлөвлөлтийн асуудал хариуцсан зөвлөх -1 (нэг) ▪ Бүс нутаг төлөвлөлт, хот төлөвлөлт, архитектор, газар зохион байгуулалт, менежмент мэргэжилтэй доктор эрдмийн зэрэгтэй эсхүл мэргэшсэн, зөвлөх инженерийн зэрэгтэй байх, ▪ Бүс нутаг төлөвлөлтийн чиглэлээр эрдэм шинжилгээний ажил, бодлого боловсруулалт төлөвлөлт хийх ажлын 10-аас дээш жилийн туршлагатай байх ▪ Бие даан ажиллах зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай байх ▪ Тухайн чиглэлийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг судлах зохих шатны хэлний мэдлэгтэй байх 9. Нийгмийн салбар, хүн ам зүйн асуудал хариуцсан зөвлөх-1 (нэг) ▪ Социологи, хүн ам зүй, статистик, хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын мэргэжилтэй, доктор, эрдмийн зэрэгтэй байх, ▪ Хүн ам зүй, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын чиглэлээр судалгаа шинжилгээний ажлын болон бодлого боловсруулах төлөвлөлт хийх ажлын 10-аас дээш жилийн туршлагатай байх ▪ Бие даан ажиллах зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай байх ▪ Тухайн чиглэлийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг судлах зохих шатны хэлний мэдлэгтэй байх

		10. Эрчим хүчний салбарын асуудал хариуцсан зөвлөх-1 (нэг) ▪ Эрчим хүчний менежмент, эрчим хүчний хангамж, эрчим хүчний салбарын мэргэжилтэй докторын эрдмийн зэрэгтэй байх ▪ Эрчим хүчний салбарын шинжилгээний ажлын болон бодлого боловсруулах төлөвлөлт хийх ажлын 10-аас дээш жилийн туршлагатай байх ▪ Бие даан ажиллах зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай байх ▪ Тухайн чиглэлийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг судлах зохих шатны хэлний мэдлэгтэй байх 11. Аялал жуулчлалын салбарын асуудал хариуцсан зөвлөх-1 (нэг) ▪ Байгалийн аялал жуулчлал, байгаль орчин, аялал жуулчлалын менежмент, газарзүйч эдийн засаг менежмент, маркетинг мэргэжилтэй, докторын эрдмийн зэрэгтэй байх ▪ Аялал жуулчлалын салбарын судалгаа шинжилгээний ажлын болон бодлого боловсруулах төлөвлөлт хийх ажлын 10-аас дээш жилийн туршлагатай байх ▪ Бие даан ажиллах зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай байх ▪ Тухайн чиглэлийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг судлах зохих шатны хэлний мэдлэгтэй байх 12. Санхүү, татварын асуудал хариуцсан зөвлөх-1 (нэг) ▪ Санхүү, эдийн засаг, бизнесийн удирдлага мэргэжилтэй, доктор эрдмийн зэрэгтэй байх ▪ Салбарын эдийн засаг болон компанийн засаглал, санхүүгийн чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлын болон бодлого боловсруулах чиглэлээр ажлын 10-аас дээш жилийн туршлагатай байх ▪ Бие даан ажиллах зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай байх ▪ Тухайн чиглэлийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг судлах зохих шатны хэлний мэдлэгтэй байх 13. Газарзүйн мэдээллийн систем, газрын зураг боловсруулах зөвлөх-1 (нэг) ▪ Газарзүйч, байгаль орчны зайнаас тандан судлал, геодези, зураг зүй, газарзүйн мэдээллийн систем мэргэжилтэй докторын зэрэгтэй байх ▪ Геодези, зураг зүй, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн чиглэлийн

		судалгаа, шинжилгээний ажлын болон газрын зураглал боловсруулах төлөвлөх хийх ажлын 10-аас дээш жилийн туршлагатай байх, ▪ Бие даан ажиллах зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай байх ▪ Тухайн чиглэлийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг судлах зохих шатны хэлний мэдлэгтэй байх 14. Математик загварчлал хариуцсан зөвлөх-1 (нэг) ▪ Эдийн засаг-математик загварчлал, хэрэглээний математик, инженер математикийн мэргэжилтэй, доктор эрдмийн зэрэгтэй байх ▪ Математик загварчлалын чиглэлээр судалгаа шинжилгээний ажлын болон бодлого боловсруулах, төлөвлөлт хийх ажлын 10-аас дээш жилийн туршлагатай байх, ▪ Бие даан ажиллах зөвлөгөө өгөх, багаар ажиллах чадвартай байх ▪ Тухайн чиглэлийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг судлах зохих шатны хэлний мэдлэгтэй байх
10	**Ажлын даалгаварт тусгагдаагүй бусад ажил**	Ажлын даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлтээр гүйцэтгэж болох бөгөөд гэрээний тусгай нөхцөлд тусгасны дагуу зохицуулна.
11	**Захиалагч байгууллага**	“Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” УТҮГ
12	**Ажил гүйцэтгэх хугацаа**	Гэрээ байгуулснаас хойш 9 сар
13	**Гүйцэтгэгч байгууллага**	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулсан хуулийн этгээд
14	**Зөвшилцөх байгууллага**	Ажлын гүйцэтгэлийн явцад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай зөвшилцөж, төлөвлөлтөд санал авч, тусгаж ажиллана.
15	**Санхүүгийн эх үүсвэр**	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
16	**Санхүүжилт**	400,000,000.00 (Дөрвөн зуун сая төгрөг)
17	**Хүлээн авах баримт**	Ажлын иж бүрдэл хэсэгт туссан судалгаа шинжилгээ, зураглал, тайлан, тооцоо, видео зэргийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр гүйцэтгэсэн программ хангамжийн эх хувилбараар "Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн" УТҮГ-т хүлээлгэж өгөх /4 хувь/.